

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/08/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.27 № 130
танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЭРДЭНЭБААТАР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 390,925.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 423,502.0 мянган төгрөгийн авлага, 188,053.3 мянган төгрөгийн бараа материал, 9,311,848.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 10,333.328.6 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 800,120.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 710,506.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,255,243.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 147,327.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 57,892.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 55,815.8 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 2,077.0 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

232420540

Аудитын гол асуудал

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн төсвөөс 23,017.7 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон зөрчилд орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж хуулийн хугацаанд ирүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах, орон нутгийн ерөнхий орлогын дансанд санхүүжилт, татварын орлогын нэр төрлийг зөрүүлэн хааж, залруулга бичилт их хэмжээгээр хийж байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,581,550.90	1,021,480.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,076,478.80	390,925.20
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	352,978.80	423,502.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	134,493.30	188,053.30
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	17,600.00	19,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,787,539.50	9,311,848.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,787,539.50	9,311,848.10
39200	Биет хөрөнгө		6,768,909.50	8,866,286.30
39300	Биет бус хөрөнгө	13	18,630.00	445,561.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,369,090.40	10,333,328.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	46,491.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	-	46,491.20
41300	Өглөг	17а, 17б	-	4,342.00
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	-	42,149.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,369,090.40	10,286,837.40
51	Засгийн газрын хувь оролцоо		8,369,090.40	10,286,837.40
51100	Засгийн газрын оруулсан капитал		537,143.60	961,600.40
51200	Хуримтлагдсан үр дүн		7,628,653.30	9,121,943.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		203,293.60	203,293.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,369,090.40	10,333,328.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруул	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,294,843.70	7,044,741.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,190,474.80	691,025.90
110	Орлогын албан татвар		324,089.00	349,653.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		324,089.00	349,653.70
113	Хөрөнгийн албан татвар		137,508.70	74,557.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		728,877.20	266,815.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,348,140.60	2,643,687.90
120	Нийтлэг татварын бус орлого		1,348,140.60	2,643,687.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,756,228.30	3,710,027.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,535,699.20	4,937,303.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,535,699.20	4,937,303.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,974,788.80	2,531,217.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		750,268.60	605,933.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		63,207.40	75,567.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		300,801.50	51,870.20
2104	Хангамж, бараа материалын зардал		105,746.90	107,482.40
2105	Нормативт зардал		1,030.80	12,220.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		32,968.00	46,172.50
2107	Томилолт, зочны зардал		6,429.00	25,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		162,805.90	961,737.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		551,530.70	644,583.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,560,910.40	2,406,086.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,759,144.50	2,107,438.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		8,996,284.80	614,147.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(7,237,140.30)	1,493,290.20

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,769,948.10	15,769,948.10
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,369,090.40	8,369,090.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,536,802.80	15,536,802.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(233,145.20)	(233,145.20)
7	Өмчид гарсан өөрчилөлт	69,428.00	69,428.00
9	Тайлант үеийн үр дүн	(7,237,140.30)	(7,237,140.30)
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,369,090.40	8,369,090.40
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,286,837.40	10,286,837.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,369,090.40	8,369,090.40
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	424,456.80	424,456.80
19	Тайлант үеийн үр дүн	1,493,290.20	1,493,290.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,217,989.00	4,658,306.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,190,474.80	691,025.90
110	Орлогын албан татвар	324,089.00	349,653.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	324,089.00	349,653.70
113	Хөрөнгийн албан татвар	137,508.70	74,557.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	728,877.20	266,815.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,621.00	17,429.20
1181	Газрын төлбөр	42,213.80	39,389.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	672,042.40	209,996.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,205.90	257,252.90
120	Нийтлэг татварын бус орлого	269,205.90	257,252.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,758,308.30	3,710,027.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,212,954.50	4,456,293.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,212,954.50	4,456,293.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,606,878.70	2,048,030.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	491,557.00	629,913.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,135.40	75,567.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	558,652.80	51,512.80
2104	Хангамж, бараа материалын зардал	143,950.50	147,916.20
2105	Нормативт зардал	1,030.60	13,010.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,501.00	23,604.30
2107	Томилолт, зочны зардал	6,429.00	25,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,267.00	922,996.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,355.40	157,858.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,606,075.80	2,408,263.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,005,034.50	202,013.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	774,633.70	789,566.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	774,633.70	789,566.60
2200	Дотоод эх үүсвэрээр	774,633.70	789,566.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(774,633.70)	(789,566.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(128,500.00)	(98,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	128,500.00	98,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	101,900.80	(685,553.60)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	974,578.10	1,076,478.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,076,478.80	390,925.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,986,144.90	2,752,136.21	234,008.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,078,444.90	1,927,988.37	150,456.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,074,744.90	1,924,372.37	150,372.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,470.80	605,933.12	9,537.68
210101	Үндсэн цалин	377,118.30	374,460.45	2,657.85
210102	Нэмэгдэл	156,664.90	140,800.52	15,864.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,656.40	13,989.80	(8,333.40)
210104	Урамшуулал	18,650.20	25,623.81	(6,973.61)
210105	Гэрээт ажлын хөлс	57,381.00	51,058.54	6,322.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,142.10	75,567.34	3,574.76
210201	Тэтгэврийн даатгал	53,718.70	51,658.24	2,060.46
210202	Тэтгэмжийн даатгал	6,355.80	6,058.74	297.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,084.70	4,871.01	213.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,271.10	1,178.62	92.48
210205	Эрүүл мэндийн даатгал	12,711.80	11,800.73	911.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	633,572.60	629,521.29	4,051.31
210301	Гэрэл, цахилгаан	76,398.00	73,773.79	2,624.21
210302	Түлш, халаалт	548,020.70	552,542.50	(4,521.80)
210303	Цэвэр, бохир ус	9,153.90	3,205.00	5,948.90
2104	Хангамж, бараа материалын зардал	67,192.50	66,830.35	362.15
210401	Бичиг хэрэг	5,756.10	5,834.40	(78.30)
210402	Тээвэр, шатахуун	50,999.20	50,976.45	22.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,006.50	4,388.36	1,618.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,430.70	5,631.15	(1,200.45)
2105	Нормативт зардал	2,154.60	2,154.00	0.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,154.60	2,154.00	0.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,872.30	38,841.61	30.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,824.10	9,823.60	0.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,631.50	1,630.30	1.20
210604	Урсгал засвар	27,416.70	27,387.71	29.00
2107	Томилолт, зочны зардал	25,122.00	25,010.00	112.00
210702	Дотоод албан томилолт	25,122.00	25,010.00	112.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	506,733.40	378,706.48	128,026.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	498,102.30	373,067.67	125,034.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,646.80	-	1,646.80
210803	Даатгалын үйлчилгээ	1,050.60	954.93	95.68
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,205.60	359.60	846.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	205.80	33.00	172.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,719.40	2,719.14	0.27
210807	Газрын төлбөр	1,802.90	1,572.15	230.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,484.60	101,808.18	4,676.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,728.00	84,055.93	4,672.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,756.60	17,752.25	4.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,700.00	3,616.00	84.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,700.00	3,616.00	84.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,700.00	3,616.00	84.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	809,200.00	726,147.84	83,052.16
223001	Бусад хөрөнгө	809,200.00	726,147.84	83,052.16
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,500.00	98,000.00	500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	98,500.00	98,000.00	500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,986,144.90	2,648,600.60	337,544.30
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,809,420.90	2,557,360.02	252,060.88
320001	Орон нутгийн төсвөөс	2,359,977.00	2,107,916.12	252,060.88
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	449,443.90	449,443.90	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	176,724.00	91,240.58	85,483.42
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,964.00	59,633.68	(3,669.68)
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,654.90	31,606.90	(952.00)
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	90,105.10	-	90,105.10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,892,752.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,892,752.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,815,785.82
2104	Хангамж, бараа материалын зардал	1,153,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,153,550.00
2107	Томилолт, зочны зардал	640,000.00
210702	Дотоод албан томилолт	640,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,022,235.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,022,235.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,076,966.18
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,076,966.18
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,076,966.18
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,892,752.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,892,752.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,500,778.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,391,974.00

Гурав. Аудитын илрүүлэлт: Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 4 тусгай сан, 2 орон нутгийн өмчит нийт 13 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвд “ИХНАЯД АУДИТ” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн. Аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ, Хэнтий шинэс СДОА-д аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн. Соёлын төв, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Өмнөдэлгэр сумын нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Харьяа орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 498,577.6 мянган төгрөгийн 9 алдааг аудитыг явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

ЗДТГ

1. *Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл 10.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.*
2. *Санхүүгийн тайланд 378.0 мянган төгрөгийн түрээсийн авлагыг тусгаагүй.*
3. *Санхүүгийн тайланд ХХОАТ-ын 96.0 мянган төгрөгийн өглөгийг дутуу тусгасан.*
4. *Үндсэн хөрөнгийн дансанд 358,332.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгийг үнэлж бүтгэж аваагүй.*

ОНХС

1. *Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс авсан зээлийн авлага 1,897.1 мянган төгрөгөөр хувь хүнээс авах авлагыг хаасан.*
2. *Хүүгийн авлага үүсгэхгүй хүүгийн орлогын 4,639.7 мянган төгрөгөөр хувь хүнээс авах авлагыг хааж бичсэн.*

Хэнтий шинэс СДОА

1. *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 23,980.0 мянган төгрөгийг цалингийн зардалд бүртгэж цалингийн зардлыг нэмэгдүүлж тайлагнасан.*
2. *Үндсэн хөрөнгийн дансанд 66,124.8 мянган төгрөгийн газрыг бүртгээгүй байна.*
3. *Үнэ төлбөргүй хүлээн авсан 43,120.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэлгүй тайлант үеийн үр дүнг нэмэгдүүлж тайлагнасан.*

Аудитаар нийт 49,168.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 1,344.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 24,805.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

ЗДТГ

1. *Түрээсийн орлогын 40 хувь 344.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. *Ахмадын сангийн харилцах дансны 7,000.0 мянган төгрөгийн гүйлгээний бүртгэл хөтлөөгүй.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

ОНХС

1. Малчдад зориулсан сургалтын зардлаас Засаг даргын тамгын газарт 4,500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авсан.
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

2. Тайлант онд 13,305.6 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаж нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Өмнөдэлгээр сумын Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ

1. Орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгөөр 1,000.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч хийдэд хандивласан.
Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,031.5 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Соёлын төв

1. Тайланд хугацааны элэгдлийн зардлыг 831.5 мянган төгрөгөөр дутуу тооцоолж санхүүгийн тайланд тусгасан.
2. Худалдан авсан 3,200.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерийг данс бүртгэлд тусгаагүй.

Аудитаар нийт 93,478.4 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 313.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 91,665.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

ЕБС

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 283 нэр төрлийн 2,653 ширхэг 389,697.4 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгүүдийг шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй.
Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Цэцэрлэг

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 104 нэр төрлийн 484 ширхэг 68,509.8 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгүүдийг шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй.
Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

ЭМТ

1. Албан хаагчдын Улаанбаатар хот, аймаг сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн 54.0 мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна.
Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон
2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан үр дүнгийн урамшуулал илүү олгосон 1,078.4 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд тайлагнаж 259.1 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байна.
Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 55 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

4. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 82,621.8 мянган төгрөгийн 8 гүйлгээ, зарлагын 9,043.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Хүснэгт 10. Зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил								
Сургууль	1	-					1	-
Цэцэрлэг	1	-					1	-
ЭМТөв	2	313.1	2	313.1				
Соёлын төв	1	1,500.0			1	1,500.0		
Дүн	5	1,813.1	2	313.1	1	1,500.0	2	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЭМТөв	1	91,665.3					1	91,665.3
Дүн	1	91,665.3	-	-	-	-	1	91,665.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	6	93,478.4	2	313.1	1	1,500.0	3	91,665.3

3.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Өмнөдэлгэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 121,093.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 23,017.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн 1 акт тогтоолсон.

3.3.1 Төлбөрийн акт

Орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн төсвөөс 23,017.7 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон.

3.3.2 Албан шаардлага

Байхгүй.

3.3.3 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	121,093.0	1	1,113.0	1	119,980.0	2	121,093.0				
ЗДТГ	4	358,816.0	4	358,816.0			4	358,816.0				
ХХС	2	6,536.8	1	4,639.7	1	1,897.1	2	6,536.8				
СДОА	3	133,224.8	1	66,124.8	2	67,100.0	3	133,224.8				
Дүн	11	619,670.6	7	430,693.5	4	188,977.1	11	619,670.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТТЗ	1	23,017.7	1	23,017.7									
ЗДТГ	2	7,344.8	1	344.8	1	7,000.0							
Нийтлэг үйлчилгээ	1	1,000.0	1	1,000.0									
ОНХС	2	17,805.6			2	17,805.6							
Дүн	6	49,168.1	3	24,362.5	3	24,805.6	-	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-						
	-	-						
Дүн	-	-						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	10	4	4	2	4			
2	ОНӨААН	2	1	1		1			
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	13	6	5	2	6			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 69

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн төсвөөс 23,017.7 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ", 60.2.4-т "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр,"; 60.2.5-д "тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг", 60.2.7-д "ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь", 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого.", 60.2.9-д "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж", 60.2.10-т "энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон санхүүжилтийн 23,017.7 мянган төгрөгийг Өмнөдэлгэр сумын Орон нутгийн ерөнхий орлогын Төрийн сан банк дахь 100180800910 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга Б.Эрдэнэбаатар, санхүүгийн албаны дарга Б.Гантулга нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН